



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 3 сарын 19 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Сонгуулийн баримт бичгийг бүртгэх
журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.15 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3, 12.6 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. “Сонгуулийн баримт бичгийг бүртгэх” журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороодын дарга нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн “Сонгуулийн баримт бичгийг бүртгэх, цэгцлэх, хүлээлцэх” журам батлах тухай 30 дугаар тогтоол, 2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах” тухай 04 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ч.СОДНОМЦЭРЭН

Ц.БОЛДСАЙХАН

000027

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн
13... дугаар тогтоолын хавсралт

СОНГУУЛИЙН БАРИМТ БИЧГИЙГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн болон хэсгийн хороо /цаашид "сонгуулийн хороо" гэх/-д сонгуулийн баримт бичгийг /цаашид "баримт бичиг" гэх/ бүртгэх, хүлээн авах, ангилах, шилжүүлэх, хүлээлцэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сонгуулийн баримт бичгийг бүртгэхэд сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ журмын дагуу зохион байгуулна.

Хоёр. Сонгуулийн баримт бичиг, түүнийг бүртгэх

2.1. Сонгуулийн хороодын үйл ажиллагааг баримтжуулах явцад дараах баримт бичиг үүсч, хөтлөгдөнө:

- 2.1.1. сонгуулийн хорооны тогтоол;
- 2.1.2. сонгуулийн хорооны даргын захирамж;
- 2.1.3. сонгуулийн хорооны хуралдааны тэмдэглэл;
- 2.1.4. сонгуулийн хорооны төлөвлөгөө, тайлан;
- 2.1.5. харилцсан албан бичиг;
- 2.1.6. өргөдөл, гомдол шийдвэрлэсэн талаарх мэдээ, тайлан;
- 2.1.7. сонгуулийн төсвийн хуваарилалт, зардлын тайлан, холбогдох баримт;
- 2.1.8. нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагч, ажиглагчийн бүртгэл;
- 2.1.9. саналын хуудас хүлээлцсэн тэмдэглэл, зарцуулалтын тайлан, мэдээ;
- 2.1.10. ирцийн мэдээ болон санал өгсөн сонгогчдын нас, хүйсийн судалгаа;
- 2.1.11. санал тоолох төхөөрөмжийн иж бүрдлийг хүлээлцсэн баримт;
- 2.1.12. санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн санал хураалтын дүнгийн хуудас.

2.2. Сонгуулийн хороод энэ журмын 2.1-д заасан баримт бичгээс өөрийн бүрэн эрхэд хамаарах баримт бичгийг бүртгэнэ.

2.3. Сонгуулийн баримт бичгийг он цагийн дараалал, төрөл тус бүрээр ангилах бөгөөд төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу хөтөлж, тусгай дэвтэрт бүртгэнэ.

2.4. Сонгуулийн баримт бичгийг бүртгэхдээ тухайн баримт бичгийн огноо, дугаар, гарын үсэг, тамга, тэмдэг зэрэг баримт бичгийн бүрдэл шаардлага хангасан эсэхийг нягтална.

2.5. Сонгуулийн баримт бичгийн бүртгэлийн дэс дугаар, огноо, доторх агуулгыг өөрчлөх, солих, засвар оруулах, бичигдсэн зүйлийг дарахыг хориглоно.

Гурав. Сонгуулийн баримт бичгийг хүлээлцэх

3.1. Сонгуулийн хороод нь үйл ажиллагааны явцад үүсгэж хөтөлсөн баримт бичгийг дараах шаардлагад нийцүүлэн бүрдүүлнэ:

3.1.1. үдэж хавтаслах хадгаламжийн нэгж 250 хүртэл хуудастай байх бөгөөд хадгаламжийн нэгжийн хуудас 250-иас илүү гарвал тэдгээрийг хэд хэдэн боть болгон хавтаслана;

3.1.2. хадгаламжийн нэгжийн дотоод товъёог, баталгааны хуудсаас бусад хуудасны баруун дээд өнцөгт харандаагаар дугаар алгасахгүй, араб тоогоор дугаарлана /баримт бичиг нь ар, өвөргүй бичвэртэй тохиолдолд ар, өвөргүй дугаарлана/;

3.1.3. хадгаламжийн нэгжийн урд талд "Ашиглалтын хуудас", "Дотоод товъёог", хойд талд "Баталгааны хуудас"-ыг заавал үднэ;

3.1.4. үдэж хавтасласан хадгаламжийн нэгжийн "Нүүр бичилт"-ийг хар өнгийн үзэг /бал/-ээр бичнэ.;

3.1.5. нүүр бичилтийн Х№, Д№, ХН№ зэрэг мэдээлэл бүхий "Архивын шифр"-ийн Х№, Д№-ыг бичихгүй бөгөөд ХН№-т тухайн баримтын бүртгэлийн дугаарыг харандаагаар бичиж түр дугаар олгоно;

3.1.6. хадгаламжийн нэгжийн нүүр бичилтэд "Эхэлсэн, дууссан огноо" бичилтийг хийхдээ тухайн хадгаламжийн нэгжид буй эхний баримтын огноо нь "Эхэлсэн огноо", сүүлийн баримтын огноо нь "Дууссан огноо" болно;

3.1.7. "Хадгалах хугацааны жагсаалтын зүйлийн дугаар" хэсэгт тухайн баримт бичгийн хадгалах хугацааг тогтоосон жагсаалтын зүйлийн дугаарыг бичнэ. Тухайлбал, ҮЖ-12, БЖ-56 гэх мэт;

3.1.8. "Хадгалах хугацаа" хэсэгт "Байнга", "15 жил НШ" гэх зэргээр хадгалах хугацааны заалтыг бичнэ.

3.2. Хэсгийн хороо бүртгэсэн баримт бичгийг санал хураалт дууссанаас хойш гурав хоногийн дотор сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлж, баримтаар хүлээлгэн өгнө.

3.3. Сум, дүүргийн сонгуулийн хороо бүртгэсэн баримт бичгийг энэ журмын 3.2-т заасны дагуу хэсгийн хороодоос ирүүлсэн баримт бичгийн хамт санал хураалт дууссанаас хойш тав хоногийн дотор аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлж, баримтаар хүлээлгэн өгнө.

3.4. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо дор дурдсан баримт бичгийг эмхлэн цэгцэлж, энэ журмын 3.1-д заасан шаардлагын дагуу үдэж хавтаслан санал хураалт дууссанаас хойш долоо хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд баримтаар хүлээлгэн өгнө:

3.4.1. санал хураалтын дүнгийн нэгтгэл /маягтаар/;

3.4.2. хэсэг дэх санал тоолох төхөөрөмж бүрээс хэвлэгдсэн санал хураалтын дүнгийн хуудас;

3.4.3. санал хураалтын ирцийн мэдээ /маягтаар/;

3.4.4. санал өгсөн сонгогчийн нас, хүйсийн судалгаа;

3.4.5. саналын хуудас хүлээлцсэн тэмдэглэл, зарцуулалтын тайлан;

3.4.6. ажлын тайлан;

3.4.7. Сонгуулийн ерөнхий хорооноос шаардсан бусад баримт бичиг.

3.5. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо энэ журмын 3.4-т зааснаас бусад баримт бичгийг аймаг, нийслэлийн архивт холбогдох журмын дагуу хүлээлгэн өгнө.

Дөрөв.Хариуцлага

4.1.Сонгуулийн баримт бичиг бүртгэх, хадгалах, хүлээлгэн өгөхдөө сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---